



## ТҮҮВЭР СУДАЛГААНЫ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

**Судалгааны сэвэв: “Монгол Улсын өрхийн санхүүгийн байдал”-ын талаарх түүвэр судалгаа**

Монгол Улсын өрхийн орлого, зарлага болон хөрөнгө, өр төлбөрийн талаарх санал асуулга явуулж, улмаар өрхийн өнөөгийн байдлыг тодорхойлж, санхүүгийн байдлыг сайжруулах боломжийн талаар бодлогын зөвлөмж боловсруулах зорилготойгоор судалгааг гүйцэтгэж байна. Тус ажлын хүрээнд Улаанбаатар болон Төв аймгуудаас түүвэр судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг гүйцэтгэх судалгааны баг, байгууллагыг холбогдох материалаа ирүүлэхийг урьж байна.

**Судалгааны ажлын нэмэлт мэдээлэл, бүрдүүлэх материал:**

Хамрах хүрээ	Улаанбаатар хот болон Төв аймгийн өрхүүд
Судалгааны баг	<ul style="list-style-type: none"><li>• Судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниуд, хүрээлэн</li><li>• Их, дээд сургуулийн багш нар</li><li>• Төрийн бус байгууллага</li></ul>
Түүврийн хэмжээ	<ul style="list-style-type: none"><li>• Улаанбаатар хотын 1,100 өрх</li><li>• Төв аймгийн 70 өрх</li></ul>
Давтамж	<ul style="list-style-type: none"><li>• 1 удаа</li></ul>
Гүйцэтгэх хугацаа	<ul style="list-style-type: none"><li>• 2022 оны 6 дугаар сарын 20-ны өдрөөс 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл</li></ul>
Гүйцэтгэх ажил, хүлээгдэх үр дүн	<ul style="list-style-type: none"><li>• Улаанбаатар хот болон Төв аймгийн өрхүүдээс асуулга авч, мэдээллийг нэгтгэн Монголбанкинд ирүүлнэ. Түүвэр судалгааны мэдээлэл нь үнэн зөв, бодитой, шаардлагад нийцсэн байх шаардлагатай.</li></ul>
Бүрдүүлэх материал	Мэдүүлгээ ирүүлж буй судалгааны байгууллага нь дараах материалуудыг ирүүлнэ: <ul style="list-style-type: none"><li>• Ажил гүйцэтгэх төсвийн санал</li><li>• Түүвэр судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг туршлагатай, ажилтнуудын мэргэшлийн бэлтгэл, томоохон төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлж байсан тухай танилцуулга</li><li>• Ажил гүйцэтгэх техникийн санал</li></ul>

Холбогдох материалаа дор дурдсан хаягаар **2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 18:00 цагаас өмнө** ирүүлнэ үү. Тус ажлын талаарх нэмэлт мэдээллийг ажлын өдрүүдэд 09:00-18:00 цагийн хооронд Монголбанкны 324060 дугаараас авч болно.

**Хаяг:** Монголбанк, Судалгаа, статистикийн газар,  
Бага тойруу 3, 15160 Улаанбаатар-46, Чингэлтэй дүүрэг